

**АВТОТЭЭВЭР БОЛОН ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН  
НЭГДСЭН ТАСАЛБАРААР ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг зүйл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр автотээвэр болон төмөр замын зорчигч тээврийн нэгдсэн тасалбараар зорчигч тээвэрлэх тээврийн ажил, үйлчилгээг аюулгүй, шуурхай зохицуулж, зохион байгуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг орон нутгийн автотээвэр болон төмөр замын зорчигч тээврийн харилцаанд оролцогч ажилтан, зорчигчдын үйл ажиллагаанд мөрдөнө. Энэхүү журмаар зохицуулаагүй харилцааг “Автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрэм”, “Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх журам”-аар тус тус зохицуулна.

1.3. Энэхүү журамд тусгагдсан нэр томъёо нь Иргэний хууль, Автотээврийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Шуудангийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудад нийцсэн байна.

**Хоёр. Зорчигч тээвэрлэлтийн ерөнхий нөхцөл**

2.1. Автотээвэр болон төмөр замын зорчигч тээврийн нэгдсэн тасалбар /цаашид Нэгдсэн тасалбар гэх/-ыг автотээврийн болон төмөр замын тээврийн тасалбар худалдаалах бүх цэгээс кассаар болон цахимаар худалдаална.

2.2. Зорчигч тээврийн нэгдсэн тасалбар худалдах ажиллагааг эхний аялал эхлэх өдрөөс 30 хоногийн өмнө эхлүүлж, аялал эхлэх цагаас 15 минутын өмнө зогсооно. Тасалбар худалдаалах цэгийн байршлаас хамаарч эрх бүхий ажилтан дээрх хугацааг өөрчилж болно.

2.3. Нэгдсэн тасалбарт 2 аяллын хоорондын хугацааг 4-өөс доошгүй цаг байхаар тооцож, тасалбар худалдаалалтыг зохион байгуулна.

2.3. Нэгдсэн тасалбарт зорчигчийн нэр, регистрийн дугаар, явах, хүрэх газрын нэр, эхний аяллын чиглэлийн нэр, дугаар /автотээврээр бол тээврийн хэрэгслийн дугаар/ зорчих байрын дугаар, үйлчилгээний цагийн хуваарь, үнэ, дараагийн аяллын чиглэлийн нэр, дугаар, зорчих байрын дугаар, үйлчилгээний цагийн хуваарь, үнэ, тасалбарын дугаар, тасалбар худалдан авсан огноо, тасалбар олгосон байгууллагын нэр, нийт үнийн дүн болон энэхүү мэдээллийг багтаасан QR кодтой байна.

2.4. Нэгдсэн тасалбар нь тээвэрлэгч, зорчигч хоёрын хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох бичиг баримт бөгөөд энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу бичигдсэн байна. Зорчигч цахим тасалбарын өгөгдлийг хүлээн авснаар тээвэрлэгч байгууллагатай тээвэрлэлтийн гэрээ байгуулсанд тооцно.

2.5. Нэгдсэн тасалбарыг 0-12 насны хүүхдэд “Автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрэм”, “Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх журам”-ын дагуу хөнгөлөлттэй олгоно.

2.6 Нэгдсэн тасалбараар зорчиж буй зорчигчийн хүсэлтээр галт тэргэнд зорчих байраа зэрэглэл ахиулан үнийн зөрүүг төлж болох бөгөөд хэрэв аялал нь хоёрдахь аялал байвал тухайн аялалдаа батлагдсан тарифын дагуу нэмэлт үнийг төлж аяллаа цааш үргэлжлүүлж болно.

2.7 Зорчигч тасалбараа үрэгдүүлсэн, гээгдүүлсэн тохиолдолд тасалбар худалдан авсан зорчигчийн талаарх мэдээлэл тасалбар түгээлтийн мэдээллийн санд бүртгэгдсэн эсэхийг баталсны үндсэн дээр иргэний биеийн байцаалттай тулган тасалбарын үнийг дахин төлүүлэхгүйгээр, тасалбар нөхөн олгохтой холбоотой үйлчилгээний нэмэлт хураамжийг төлүүлэн, зорчигчид зорчих тасалбарыг нөхөн олгож болно. Тасалбар нөхөн олгох нэмэлт үйлчилгээний хураамж нь тасалбарын нийт үнийн дүнгийн 1 хувиас ихгүй байна.

2.8. Зорчих тасалбарт нэр нь бичигдсэн зорчигч уг тасалбараар үйлчлүүлнэ. Аяллын дундуур зорчих тасалбарыг дур мэдэн өөр зорчигчид шилжүүлэхгүй ба хэрэв шилжүүлсэн бол хүчингүйд тооцно.

2.9. Нэгдсэн тасалбарт тэмдэглэсэн аяллын хугацаанд тухайн тасалбар хүчинтэй.

2.10. Төлбөрийг буцаан олгох:

2.10.1. Нэгдсэн тасалбарын төлбөрийн буцаалтыг зорчигчийн эхний аялал явах газрын тасалбар худалдаалах цэгээс ажлын 3 хоногт багтаан бэлэн мөнгөөр буцааж олгоно.

2.10.2. Зорчигч тасалбар буцаах хүсэлт гаргаж тээвэрлэгч байгууллагын эрх бүхий ажилтны зөвшөөрлөөр буцаалт хийгдэнэ.

2.10.3. Зорчигч тээврийн үйлчилгээнд зорчигч тээвэрлэлтийн гэрээг цуцалсан тохиолдолд дор дурдсанаас ихгүй үйлчилгээний хөлсийг суутган авна.

- эхний аялал хөдлөхөөс өмнө 2-оос дээш цагийн өмнө буцаавал нийт төлбөрийн 10 хувь,
- эхний аялал хөдлөхөөс өмнө 2 хүртэл цагийн дотор буцаавал эхний аяллын төлбөрийн 20 хувь, дараагийн аяллын төлбөрийг энэхүү журамд заасан хугацаагаар тооцно,
- эхний аялал хөдөлснөөс хойш 60 хүртэл минутын дотор буцаавал нийт төлбөрийн 50 хувь, дараагийн аяллын төлбөрийг энэхүү журамд заасан хугацаагаар тооцож тус тус олгоно.

2.10.4. Хэрэв зорчигч нь замд өвдөх зэрэг хүндэтгэх шалтгаанаар цааш явж чадахгүйд хүрвэл замын үлдсэн зайд ногдох зардлыг энэхүү журамд заасан хугацаагаар тооцож буцаан авна.

2.10.5. Зорчигч нэгдсэн тасалбарт заагдсан хугацаанаас өмнө явах болсон тохиолдолд худалдан авсан тасалбараа энэхүү журамд заасны дагуу буцааж, дахин нэгдсэн тасалбар худалдан авч зорчино.

2.11. Зорчигч галт тэрэг болон автобусанд суух үед цахим тасалбарыг хэвлэмэл байдлаар бэлдэж, өөрийн бичиг баримтын хамт шалгуулна.

2.12. Буцаалт хийгдсэн тухай мэдээллийг тасалбар худалдаалах цэгийн ажилтан тасалбар түгээлтийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэж, тээвэрлэгч байгууллагын холбогдох эрх бүхий ажилтан баталгаажуулсны үндсэн дээр буцаалтыг хийнэ.

2.13. Тээвэрлэгч байгууллагууд сар бүр тасалбар худалдаалалтын талаар тооцоо нийлнэ.

## **Гурав. Зорчигч тээврийн нэгдсэн тасалбарыг хэвлүүлэх, ашиглах**

3.1. Орон нутаг, хот хоорондын зорчигчийн нэгдсэн тасалбарыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Улаанбаатар төмөр зам” ХНН нэгдсэн байдлаар хэвлүүлэх, хуваарилах, цахим системээр худалдаалах ажлыг гүйцэтгэнэ.

3.2. Төлбөрийн картыг ашиглахдаа “Журам шинэчлэн батлах тухай” Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-160 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөнө.

3.3. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Улаанбаатар төмөр зам” ХНН тасалбар түгээлтийн нэгдсэн мэдээллийн сантай байх бөгөөд цахим тасалбарыг тус мэдээллийн санд мөн бүртгэнэ. Зорчигчийн нэгдсэн тасалбарыг нэгдсэн журмаар унших, ашиглах боломжтой байна.

3.4. Тээвэрлэгч байгууллагууд тасалбар худалдаалах болон санхүүгийн ажилтанд хүндрэл учруулахгүй байхаар програм хангамжийг хөгжүүлнэ. Нэгдсэн тасалбарыг бэлэн мөнгөний нэгэн адил үзэж, хариуцуулсан ажилтны тайлан, тооцоонд сар тутам дотоодын хяналт тавих бөгөөд зорчих тасалбарыг үрэгдүүлэх, завших, ашиглах зөрчил илэрвэл холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

3.5. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, иргэд нэгдсэн тасалбарыг хуурамчаар үйлдэх, бусдад шилжүүлэх, дамжуулан худалдаалахгүй.

3.6. Зам, тээврийн хөгжлийн яамнаас батлагдсан тээвэрлэлттэй холбогдсон баримт бичгийг мөрдөөгүй, зорчих тасалбарыг хуурамчаар үйлдсэн, хэвлэж ашигласан, дамжуулан худалдсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ.

\_\_\_ оОо \_\_\_

“Автотээвэр болон төмөр замын зорчигч тээврийн нэгдсэн тасалбараар зорчигч тээвэрлэх журам”-ын 1-р хавсралт

**ХОТ ХООРОНД, ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧИЙН  
НЭГДСЭН ТАСАЛБАРЫН ЗАГВАР**



ЗОРЧИХ ТАСАЛБАР  
TRAIN & BUS TICKET  
91-200881301182



**ГАЛТ ТЭРЭГ**

Хаанаас / From  
САЙНШАНД  
SAINSHAND

Хашаа / To  
УЛААНБААТАР  
ULAANBAATAR

2020-08-21  
(Ба)  
19:58



2020-08-22  
(Бя)  
06:55

Галт тэрэг: 285 САЙНШАНД - УЛААНБААТАР  
Train № SAINSHAND - ULAANBAATAR

Вагон Wagon 5 Нийтийн	Суудал Seat 1
-----------------------------	---------------------

**АВТОБУС**

Хаанаас / From  
УЛААНБААТАР  
ULAANBAATAR

Хашаа / To  
ХЭНТИЙ  
KHENTIИ

2020-08-22  
(Бя)  
08:00



2020-08-22  
(Бя)  
13:00

Автобус : УЛААНБААТАР - ХЭНТИЙ  
BUS : ULAANBAATAR-KHENTIИ

Автобус № Bus plate № 06-93 УНИ	Суудал Seat 4
---------------------------------------	---------------------

Зорчигчийн мэдээлэл:  
Passenger information

Овог: Е  
Нэр: ГҮНЖ  
Регистр: ЕЮ13211121  
Ангилал: Хүүхэд/Child

Худалдан авсан огноо:  
2020-08-21 14:39:24



**Билетийн үнэ**

Галт тэрэг : 8,000      Автобус : 16,000

Нийт үнэ : 24,000

Сугалаа: UD 11823992 Дүн: 24,000  
ДДТД: 000002076675888200821008800001167

Та аян замдаа сайн яваарай !